



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Эдийн засаг, Бизнесийн сургууль**

Хөтөлбөрийн нэр: **“Маркетинг” бакалаврын сургалтын хөтөлбөр**

Индекс: **D041401**

Шинжээчийн баг:

Ахлагч: Г.Болдбаатар /Монголын маркетингийн хөгжлийн академийн ерөнхийлөгч, доктор, профессор/

Гишүүд: Б.Даваасүрэн / Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн Маркетинг, худалдааны тэнхимийн эрхлэгч, доктор, профессор/

О.Бурмаа / Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Бизнес удирдлагын тэнхимийн багш, доктор, дэд профессор/

2021.11.10

# Агуулга

## Товчилсон үгийн тайлбар

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

### II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

### IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

### V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

### VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

### VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

## Товчилсон үгийн тайлбар

1. БНСУ – Бүгд Найрамдах Солонгос Улс
2. БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс
3. БМИҮЗ – Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
4. БСШУЯ – Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
5. БСШУСЯ – Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
6. БШУ- Боловсрол, Шинжлэх ухаан
7. ӨМӨЗО – Өвөр Монголын Өөртөө Засах Орон
8. ТББ – Төрийн бус байгууллага
9. ХАА – Хөдөө аж ахуй
10. ХААИС – Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
11. ХЕХ – Хөтөлбөрийн ерөнхий хороо
12. ЭЗБС – Эдийн засаг, бизнесийн сургууль

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Хөдөө аж ахуйн их сургууль эдийн засаг, бизнесийн сургууль Mongolian university of life sciences	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Маркетинг Marketing	
<b>Индекс</b>	D041401	
<b>Шинжээчид</b>	<ol style="list-style-type: none"> <li>Овог нэр: Гончигжав Болдбаатар Ажил албан тушаал: Ахлагч Ажлын газар: Монголын маркетингийн хөгжлийн академийн ерөнхийлөгч, доктор (Ph.D), профессор</li> <li>Овог нэр: Батсүх Даваасүрэн Ажил албан тушаал: гишүүн Ажлын газар: Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн Маркетинг, худалдааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор</li> <li>Овог нэр: Отгонбаяр Бурмаа Ажил албан тушаал: гишүүн Ажлын газар: Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Бизнес удирдлагын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор</li> </ol>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Г.Даваажаргал. БМИҮЗ-ийн Ажлын албанымагадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	09/28	Шинжээчийн багийг томилсон тушаалтай танилцах
	09/28	Мэргэжилтэнд шинжээчдийн багаас ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар санал өгөх
	09/29	Шинжээчид гэрээ байгуулах
	09/29	Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах.
	10/07	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	10/25, 26	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	11/04	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	11/04	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	11/05	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	11/08	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.	
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн нэр, индекс	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
Маркетинг D041401	Л.Отгонжаргал	өдөр	4 жил	127

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг БШУ-ы сайдын 2014 оны А/78 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага батлах тухай” журмын дагуу стандарт шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.
- Хөтөлбөр нь ХААИС-ийн захирлын 2014 оны “Хөтөлбөрийн хорооны журам” А/228 дугаар тушаал, ХААИС-ийн захирлын 2014 оны “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам” А/427 тоот тушаал, Бүрэлдэхүүний сургууль, тэнхим, хөтөлбөр батлах тухай захирлын 2014 оны А/202 тоот тушаалын дагуу боловсрогдсон байна.
- ХААИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий Хорооны шийдвэр болон Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн ажлын албаны захирлын 2019.09.04-ны өдрийн 204 тоот тушаалаар батлагдсан “Өөрийн үнэлгээний тайланд тавих шаардлага”-ын дагуу хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг бичиж боловсруулсан байна.
- Хөтөлбөрийг ХААИС-ийн ЭЗБС-ийн Захиргааны зөвлөлийн 2021.04.16-ны өдрийн хурал, мөн Сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2021.09.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлэн батлуулсан байна.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг Дэлхийн зах зээл дэх маркетингийн мэргэжлийн эрэлт, хэрэгцээний чиг хандлага (2015 оны дэлхийн эдийн засгийн форумын мэдээлэл, 2020 оны ажиллах хүчний нөөцөд урт болон богино хугацаанд цар тахлын үзүүлэх нөлөөг харгалзсан ирээдүйн ажлын байрны нөөцийг судалгаа, 2015 оны дэлхийн эрэлттэй мэргэжлийн судалгаа, “Маркетинг” мэргэжлийн нэр 2020 оноос “дижитал маркетинг”-тай холбогдох болж, үндсэн ажил үүргийн 45 хувь нь шинэчлэгдэж ажлын байрны эрэлт өсөж байгаа судалгаа)-д тулгуурлан тодорхойлсон байна.

- Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд маркетингийн мэргэжлийн эрэлт, хэрэгцээний байдал (“Маркетинг” мэргэжлийн эрэлтийн судалгаа (<http://mongolcom.mn/read/2975>), (<http://ikon.mn/opinion/>, НЗДТГ-ын гарын авлага, 2017.), Маркетингийн судалгааны ММСГ компанийн “CEO survey 2020” судалгаа (ММСГ, 2020, хууд. 27), маркетингийн СМО-ийн судалгаа (<https://www.bzp.mn/>, 2021.05.21), аж ахуйн нэгжийн маркетингийн менежерийн хэрэгцээ (ҮСХ, 2021)) судалгааны мэдээллүүдэд үндэслэн тодорхойлжээ.
- ХААИС болон БНХАУ-ын Өвөрмонголын Багшийн их сургуулийн (ӨМБИС) хоорондын оюутан суралцуулах 2015.03.16-ны өдрийн гэрээгээр “Аялал жуулчлал”-ын мэргэжлээр, ХААИС болон Northwest A&F их сургуулийн Эдийн засаг, менежментийн коллежийн 2015.04.21-ний өдрийн гэрээгээр “Цахим худалдаа, маркетинг” мэргэжлээр оюутан солилцох гэрээг үндэслэн шинэ сонгон мэргэших чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа ба үүнийг нь Монголын Аялал Жуулчлалын Холбоо, Монголын Маркетингийн Холбоо дэмжсэн санал ирүүлсэн байна.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр боловсруулах, батлуулах, гүйцэтгэх, үнэлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх механизмын хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарах

### **Зөвлөмж:**

- Монголын хөдөө аж ахуйн салбарын зах зээл дэх маркетингийн мэргэжлийн эрэлт, хэрэгцээний чиг хандлагыг судлан түүнд нийцүүлэн хөтөлбөрийн шинэчлэл хийхэд анхаарах

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- ЭЗБС-ийн хөтөлбөрийн хороо, ХААИС-ийн ХЕХ-ны 2017.05.10-ны өдрийн хурлаар батлуулсан хөтөлбөрийн зорилгод мэргэжлийн ур чадвараас гадна хувь хүний ёс зүй, хандлагыг тусган төлөвлөсөн. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 50 хичээлийн стандарт хөтөлбөрийг хичээлийн сэдэв бүрээр олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлсон.
- Сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2021.09.15-ны өдрийн хурлаар мэргэжлийн онцлогийг харгалзан “Маркетинг” хөтөлбөрийг “аялал жуулчлалын маркетинг, цахим худалдаа, маркетинг” чиглэлээр гүнзгийрүүлэн мэргэшихээр боловсруулж хэлэлцүүлэн батлуулсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- “Төгсөгчдийн сэтгэл ханамж”, “Сургалт, үйлдвэрлэлийн дадлагын арга хэлбэр”-ийн судалгаа, “Ажил олгогчийн санал”-д үндэслэн төгсөгчдийн загварыг мэргэжлийн болон харилцаа, хувь хүний ур чадвараас гадна нийгэм, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт оруулах хувь нэмрийг тусган “бүтээлч, судлаач төгсөгч” загварыг зураглаж боловсруулсан.
- WEF-ын болон хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа болон хөтөлбөрийн оролцогч талуудын судалгаа, Монголын маркетингийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж,

саналыг хүлээн авч мэргэжлийн шинэ эрэлттэй чиг хандлагыг харгалзан хичээлийн хөтөлбөрийн агуулга, хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн үр дүнг тасралтгүй сайжруулах, суралцагчдын мэдлэг, ур чадвар болон төгсөгчдийн загварыг сайжруулдаг үйл ажиллагаа хэвшиж байна.

**Зөвлөмж:**

- ХААИС-ийн Маркетинг хөтөлбөрийн онцлог, давуу талыг дижитал ертөнц, даяарчлагдсан нийгэмд шаардлагатай хэрэгцээтэй маркетингийн мэдлэг чадварыг түлхүү олгоход анхаарснаар өөрийн давуу тал, ялгарлыг бий болгох.

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- “Маркетинг” хөтөлбөр нь ХААИС-ийн ЭЗБС-ийн Захиргааны зөвлөлийн 2021.04.16-ны өдрийн хурал, ХААИСургуулийн Эрдмийн зөвлөлийн 2021.09.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлэн батлагдсан байна.
- “Маркетинг” хөтөлбөрийн хүрэх зорилго, зорилт (PEO), хөтөлбөр (PLO), хичээлийн (CLO) суралцахуйн үр дүн нь тодорхой, хоорондоо уялдаатай төлөвлөгдсөн, хөтөлбөрийг цогцоор хэрэгжүүлэх, үр дүнг хянах, тогтмол сайжруулах нэгэн цогц баримт бичиг бүрдсэн байна.
- ХААИС, Хөтөлбөрийн Ерөнхий Хорооны журам, Захирлын 2015.11.24-ны өдрийн А/377 тоот тушаалын дагуу “Маркетинг” хөтөлбөрийг тэнхимийн мэргэжлийн хороогоор хэлэлцэн, ЭЗБС-ийн хөтөлбөрийн хороогоор зөвшөөрүүлэн ХААИС-ийн ХЕХ-ны хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна.
- Хөтөлбөрийн агуулгыг сайжруулахад төгсөгчид, ажил олгогчид, мэргэжлийн холбоод, хамтран ажилладаг 28 мэргэжлийн судалгааны болон зөвлөх агентууд, компаниудын саналыг байнга тусган ажилладаг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын үр дүнд суралцагч эзэмшин төгсөх цогц чадамжийг тодорхойлсон “Маркетинг” хөтөлбөрийн зорилго (PEO), хөтөлбөр (PLO), хичээлийн (CLO) суралцахуйн үр дүнгийн матрицийг боловсруулсан байна.
- “Маркетинг” мэргэжлийн дэлхий нийтийн болон монголын эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн аялал жуулчлалын маркетинг болон цахим худалдаа, маркетингийн чиглэлээр нарийн мэргэшсэн бэлтгэхээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөндөө шинэчлэл хийн ажиллаж байгаа нь уг хөтөлбөрийн онцлог, давуу тал болж байна.

**Анхаарах асуудал:**

- “ХАА-н маркетинг”-ийн чиглэлийн хичээлүүдийн агуулгыг хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнтэй уялдуулан сайжруулж төгсөгчдийн ялгарах давуу шинжийг бүрдүүлэхэд анхаарах.

### **Зөвлөмж:**

- “Маркетинг” хөтөлбөр дэх маркетингийн хичээлүүд, хичээлийн агуулгад ХАА-н салбарын маркетинг, цахим худалдаа, цахим маркетингийг ХАА-н салбарт хөгжүүлэх онол, арга зүй, дадлагыг бүрдүүлэхэд анхаарах
- Оюутны үйлдвэрлэлийн дадлагыг ХАА-н салбар, нэгжид, орон нутагт хийлгэх, дадлагажуулахад анхаарах

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- 1997 оноос хойш хэрэгжиж ирсэн, олон жилийн туршлагатай хөтөлбөр
- Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж ирсэн. Төгсөгчдийн хөтөлбөрийн агуулгад өгсөн үнэлгээ сайжирсан.
- Боловсролын эрх бүхий дээд байгууллагуудаас тавигддаг дүрэм журамд нийцсэн.
- Сургалтын хөтөлбөрийн удирдлагын системийг тасралтгүй сайжруулж ирсэн.
- Оюутны дадлага практикийн ажлыг чухалчилдаг.
- Ажил олгогч, төгсөгчдийн уулзалтын үр дүнгээс харахад төгсөгчдийн ажлын ачаалал даах чадвар, үг даах чадвар сайн.

#### **Анхаарах асуудал:**

- Сургууль, тэнхимийн алсын харааг Цахим худалдаа, бирж, Дижитал маркетинг, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Виртуаль лаборатори хэмээн тодорхойлсон хэдий ч Маркетингийн хөтөлбөр нь эдгээр чиглэлд сайжруулалт хөгжүүлэлтийг хараахан хийгээгүй байна.
- Сүүлийн таван жилд оюутны сонгон суралцах боломжийг нэмэгдүүлсэн хэмээн өөрийн үнэлгээний тайланд тусгасан боловч тайлангийн Хүснэгт 2.3 болон батлагдсан сургалтын төлөвлөгөөг харахад нийт хичээлд сонгон судлах



- хичээлийн хувь хэмжээ 2011 оныхоос буурч 11.8%-д хүрсэн байна.
- Гадаад хэл эзэмшилтэд төгсөгчдийн болон ажил олгогчдын 80 орчим хувь нь дундаас доогуур үнэлгээ өгсөн.
- Хичээлийн суралцахуйн үр дүнгийн матрицыг төгсөгчдөд эзэмшүүлэх мэдлэг, ур чадвартай уялдуулсан хэдий ч хичээлийн үнэлгээтэй уялдуулаагүй.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/ ойлгомж муутай, алдаатай зурагдсан.

#### **Зөвлөмж:**

- Сургууль, тэнхимийн алсын хараа болох Цахим худалдаа, бирж, Дижитал маркетинг, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Виртуаль лаборатори гэсэн чиглэлд хөтөлбөрийн сайжруулалт хөгжүүлэлтийг хийх
- Оюутны хичээл болон багшийг сонгон судлах боломжийг нэмэгдүүлэх.
- Хичээлийн суралцахуйн үр дүн, үнэлгээний матрицыг төгсөгчдөд эзэмшүүлэх мэдлэг, ур чадвартай холбон нарийвчлан тодорхойлдог байх.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/-ыг дахин зураглах.
- Оюутны гадаад хэлний мэдлэгийг сайжруулахад анхаарах.
- Маркетингийн орчин үеийн чиг хандлага болсон дижитал маркетинг, сошиал маркетинг, мэргэжлийн программ хангамж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаарх мэдлэг ур чадварыг олгох чиглэлд сургалтын хөтөлбөрийг сайжруулах.
- Оюутны өөрийгөө илэрхийлэх ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх тал дээр анхаарах.

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын арга зүйд хийсэн анализ судалгааны баримт материал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын арга зүйн боломжит төрлүүдийг сургалтад ашигладаг.
- Сургалтын арга зүйг тогтмол сайжруулдаг.
- Цахим сургалтын эрх зүйн баримт бичгүүд боловсруулагдсан.
- Асуудалд суурилсан, нөхцөлд суурилсан сургалтын арга зүйг хэрэглэдэг.
- Маркетингийн багш нарын сургалтын арга зүйг суралцагчид хангалттай сайн гэж үнэлдэг.

#### **Анхаарахасуудал:**

- Бизнес маркетингийн сургалтын орчин үеийн арга зүйн судалгаа хийгддэггүй. Орчин үеийн заах аргуудын нэвтрэлт тааруу.
- Оюутны цогц чадамжийг тодорхойлон, сэтгэн бодох, шийдвэр гаргах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтын арга зүйг нэвтрүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Бизнес, маркетингийн сургалтын орчин үеийн шинэлэг арга зүйг судалж, нэвтрүүлэх

- Оюутны цогц чадамжийг тодорхойлон, сэтгэн бодох, шийдвэр гаргах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтын арга зүйг нэвтрүүлэх.
- Мэдээлэл технологид суурилсан сургалтын арга зүйд суралцах.

### 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны мэдлэг, ур чадварын үнэлгээний арга зүй сайжран хөгжиж байна.
- Үнэлгээнд хувь хүний хандлага, зөөлөн ур чадваруудыг үнэлдэг болсон.
- Ажил олгогчдоос төгсөгчдийн хувь хүний хандлагыг сайнаар үнэлсэн.
- Багшийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж хэвшсэн.

#### Анхаарах асуудал:

- Сургалтын үр дүнг үнэлэх (багш, оюутан, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамж) олон талт үнэлгээний системийг хэрэгжүүлдэг боловч хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг нэгдсэн байдлаар уялдуулан дүн шинжилгээ хийгээгүй.
- Зарим хичээлийн үнэлгээний үр дүн нормаль тархалттай бус байна.

#### Зөвлөмж:

- Сургалтын үр дүнг үнэлэх (багш, оюутан, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамж) олон талт үнэлгээний системийг хэрэгжүүлэх зорилго бүхий судалгааны үр дүнгүүдийг нэгдсэн байдлаар уялдуулан дүн шинжилгээ хийдэг байх.

#### 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн онцлогтой холбоотой сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан

- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын гадаад болон дотоод орчны талаарх суралцагчдын болон багш нарын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, тайлан

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- БСШУЯ-ны нийтлэг шаардлагууд болон боловсролын байгууллагад тавигдах стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан сургалтын орчинтой.
- Сургалтын зориулалтын тохижилттой анги танхимыг шинэчлэн сайжруулж, сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан.
- Сургалтын орчныг сайжруулахад оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын орчны талаарх оролцогч талуудын сургуулийн хэмжээнд хийгдсэн судалгаа байгаа боловч хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн үр дүнгүүд байхгүй байгааг анхаарах шаардлагатай.
- Сургуулийн дотоод орчинд анхаарах, хэдийгээр 1GB хурдтай интернэттэй болсон хэдий ч оюутнуудын хувьд энэ нь учир дутагдалтай байна. 00-н асуудал, Team working хийх өрөө, багш нартай харилцах өрөө гэх мэт асуудлуудыг шинэчлэн сайжруулах шаардлагатай.
- Оюутнуудын сургалтын орчинд өгөх сэтгэл ханамжийн судалгаа 3.2-3.8 хооронд байгаа нь цаашид илүү сайжруулах хэрэгцээтэйг харуулж байна.

#### **Зөвлөмж:**

- Сургуулийн гадаад орчин талаасаа машины зогсоол, сургуулийн экстерьер дизайны асуудлуудад анхаарч ажиллах
- Багш нарын гаргасан ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийг борлуулах өөрийн сургуулийн Brand book shop-г бий болгож, оюуны өмчийг зах зээлийн эргэлтэд оруулах
- Сургалтын цахим орчны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд оюутнуудад интернэтгүй орчинд нэвтрэх боломжоор хангах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн сургалтыг тасралтгүй явуулахад шаардагдах техник, программ хангамж, тоног төхөөрөмжөөр хангагдсан.

- Сургалтын интернэт орчныг жил бүр сайжруулан шинэчилж, интернэтийн хурдны хэмжээг 1GB болгож өсгөсөн.
- Сургалтын агуулгыг E-Контентын түвшинд байнга боловсруулан Google G-Suite пламформ дээр E хичээлүүдийг байршуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Орчин үеийн шинэлэг программ хангамжуудыг маркетингийн сургалтад нэвтрүүлэх

#### **Зөвлөмж:**

- E-Learning системийн хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр анхаарах
- Мэргэжлийн болон мэргэшүүлэх суурь хичээлүүдэд ашиглаж буй программ хангамжийг албан ёсны лицензтэй болгон өргөжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр суралцагсад нь Монгол болон гадаад хэл дээр хэвлэгдсэн 1793 төрлийн 8710 ном, сурах бичгийг ЭЗБС-ийн номын сангаас авч ашиглах боломжтой.
- Жил бүр хөтөлбөрт ашигладаг сурах бичиг, номын фондыг нэмэгдүүлж, баяжуулалтыг хийдэг ба номын хүрэлцээ хангалттай.
- Springer link, Ebsco, fao, wipo, goali зэрэг олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн эх үүсвэрийг ашиглах боломжтой.
- ЭЗБСургууль нь шинээр 4 давхар бүхий орчин үеийн техник, технологиор тоноглогдсон номын сангийн өргөтгөлийг хийж буй нь сайшаалтай.

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн ном, сурах бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, сүүлийн жилүүдэд туурвигдсан гадаад болон дотоодын бүтээлүүдээр ном, сурах бичгийн захиалгыг нэмэгдүүлж, баяжуулалт хийх

#### **Зөвлөмж:**

- Гадаад номын захиалгын тоо болон нэгж номын тоо ширхгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах
- Хөтөлбөрөөр суралцагчдын цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэр ашиглах боломжийг нэмэгдүүлж, суралцагчдад түүнийг хэрхэн ашиглах чиглэлийн зөвлөмжүүдийг тогтмол өгдөг байх
- E-Номын сангийн үйлчилгээг сайжруулах

## Шаардлага

- Хөтөлбөрөөр суралцагчдын ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сүүлийн үеийн бүтээлүүдээр ном, сурах бичгийн баяжилт хийх

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн ерөнхий хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, мэргэжлийн хөтөлбөрийн хороо гэсэн бүтэц, чиг үүрэгтэйгээр хөтөлбөрийг зохион байгуулдаг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд бүрдсэн.
- Хөтөлбөрт ирсэн санал, гомдлыг багш, оюутан, сургалтын үйл ажиллагаагаар ангилан сургуулийн дотоод журам, дүрмийн дагуу тодорхой хороодоор шийдвэрлэдэг.

#### Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн удирдлага буюу сургалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн алба, ЭЗБС-ийн сургалтын алба, хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн уялдаа холбоог бэхжүүлэх

#### Зөвлөмж:

- Багшийн болон хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн урт болон богино хугацааны төлөвлөгөөг сургуулийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулах

### 4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг

байна.

**Илрэл нотолгоо:**

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагчдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь БНХАУ, БНСУ, ӨМӨЗО, Словак, Нидерланд, Унгар болон Австри улсуудын их, дээд сургуулиудтай хамты ажиллагааны гэрээгээр оюутан солилцоо, зочин профессор ажиллуулах, хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах замаар хамтран ажилладаг.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн 17 хүний бүрэлдэхүүнтэй холбоотой.
- Оюутнуудыг ажил олгогчидтой холбон дадлага хийлгэх, цагийн ажилд зуучлах зэрэг ажлуудыг багш нар түлхүү хийдэг.

**Анхаарах асуудал:**

- Багш болон суралцагчдын хувьд нийгэмд үзүүлэх үйлчилгээнд тогтмол хамрагдах сонирхолтой хэдий ч уг ажлыг профессор багшийн ажиллуулах журамд тусгаагүйгээс үүдэж, олон төрлийн ажлууд орхигдох магадлалтай.
- Гадаадын хамтын ажиллагаатай их, дээд сургуулиуд олон хэдий ч тухайн хөтөлбөрт оюутнуудыг идэвхжүүлэн оролцуулах, бэлтгэх, уриалах чиглэлийн ажлуудыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй.
- Төгсөгчийн холбооны зохион байгуулдаг тогтмол үйл ажиллагааг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх шаардлагатай.

**Зөвлөмж:**

- Гадаадын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй оюутан солилцооны хөтөлбөрөөр суралцагчдын тоог нэмэгдүүлэх

**4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь БНХАУ, БНСУ, ӨМӨЗО, Словак, Нидерланд, Унгар болон Австри улсуудын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээгээр оюутан солилцоо, зочин профессор ажиллуулах, хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах замаар хамтран ажилладаг.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн холбоотой. /17 хүний бүрэлдэхүүнтэй/
- Оюутнуудыг ажил олгогчидтой холбон дадлага хийлгэх, цагийн ажилд зуучлах зэрэг ажлыг багш нар түлхүү хийдэг.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зарцуулж буй зардлын задаргааг илүү тодорхой төлөвлөх

### **Зөвлөмж:**

- Орлогын бусад эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарах (Судалгаа шинжилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, захиалгат төсөл хэрэгжүүлэх, бизнес зөвлөгөө өгөх, гарааны бизнес, бизнес инкубатор ажиллуулах гэх мэт)

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй.
- Жил бүр хөдөлмөрийн зах зээлийн тандах судалгааг хийдэг давуу талтай.

### **Анхаарах асуудал:**

- Маркетингийн идэвхижүүлэлтийн боломжит бүхий л хувилбарыг (жишээ нь хэвлэмэл сурталчилгаанд тэмдэглэлийн дэвтэр, үзэг, календарь, хувцас, гэх мэт) амжилттай хэрэглэдэг уламжлал тогтсон хэдий ч орчин цагийн маркетингийн шинэлэг сувгуудыг үйл ажиллагаандаа ашиглах
- ХААИС-ийн “Маркетинг” бакалаврын хөтөлбөрийн онцлогийг олон нийтэд таниулах, хүрэх үр дүнг нэмэгдүүлэх

### **Зөвлөмж:**

- Маркетингийн идэвхжүүлэлтийн болон элсэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн тухайн цаг үед нь бус хичээлийн жилээр нь төлөвлөх ба зарцуулах төсвийг нэмэгдүүлэх.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа
- Удирдлага мэдээллийн системийн хэрэгжилт

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс сүүлийн 5 жилд 6 сурах бичиг, 18 гарын авлага, редакторлосон ном, сурах бичиг, 11 зохиогчийн эрх бүхий бүтээлүүдийг хэвлэн нийтлүүлсэн.
- Вебсайтын бүтцэд байх ёстой мэдээллүүдийг бүрэн хамруулсан давуу талтай.

##### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын нийгэмд танигдсан нэр хүнд, амжилт бүтээлд тулгуурлан хөтөлбөрийг олон нийтэд таниулах

##### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн талаарх мэдээ, мэдээллийг зөвхөн өөрийн сургуулийн эх сурвалжаар дамжуулах бус, хөтөлбөрийн онцлогийг илтгэх нийгмийн бусад сүлжээг ашиглах
- Хөтөлбөрийн мэдээллийн ил тод байдлыг хангахдаа сургуулийн дотоод орчинд уламжлалт сувгуудыг ашиглан, суралцагчдад хүртээх

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааны судалгаа.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургууль нь өөрийн элсэлтийн журамтай.
- Шинэ элсэгчдэд зориулсан гарын авлагатай, хичээлийн жил бүр тогтмол шинэчлэн гаргадаг.
- Хөтөлбөрөөр бүртгүүлсэн болон элсэгчдийн харьцаа тэнцвэртэй.



### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн зорилгын онцлогтой уялдуулан элсэгчдэд тавигдах шаардлагаа шинэчлэн сайжруулах
- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах

### **Зөвлөмж:**

- Элсэхээр хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааг жил бүр тодорхойлдог судалгааны үр дүнд ямар асуудлуудыг бодлогоор дэмжиж сайжруулсан болон хэрхэн өөрчлөлт оруулсан талаар дүн шинжилгээ хийж хэвших

## **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Оюутнуудад сургалтын, нийгмийн, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, хувь хүний төлөвшил, хөгжлийг дэмжих болон мэдээ мэдээллийн гэсэн үндсэн чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээг явуулдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчдад чиглэсэн урлаг, спортын болон олон нийтийн 10 гаруй үйл ажиллагаа тогтмолжсон.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгааны арга барилыг хөгжүүлэх чиглэлд анхаарах
- Хөтөлбөрөөр суралцагчдаас сургуулийн бүтэц, нэгжийн үйлчилгээ, хүртээмж, харилцааны талаарх судалгааг цогцоор нь авч, үр дүнг хэмжих
- Суралцагчдыг төсөлт ажил, судалгааны ажил, судлаачдын хамтарсан бүтээлүүдэд судлаачаар хамруулахад хөтөлбөрийн зүгээс бодлогоор хангаж, зөвлөн туслах

### **Зөвлөмж:**

- Суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих болон сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлэх

## **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил болон үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчдын тоо, үр дүнгийн мэдээлэл

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Тус хөтөлбөрт суурилсан мэргэжлийн хэд хэдэн клуб үйл ажиллагаагаа явуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- “Сургалтын журам”-д хөтөлбөрөөр суралцагчдад олгох урамшууллын тогтолцоо байгаа хэдий ч түүнийг хүртсэн оюутны тоо нь хязгаарлагдмал.

#### **Зөвлөмж:**

- Мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнд суралцагчдыг идэвхжүүлэн дэмжиж, үр дүн гаргасан суралцагчдад урамшуулал олгоход анхаарах

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр суралцагч оюутнуудыг хамарсан мэргэжлийн 3 төрлийн клуб үйл ажиллагаагаа явуулдаг.
- Суралцагчдад чиглэсэн сайн дурын 10 төрлийн ажиллагаа сүүлийн 5 жилийн хугацаанд зохион байгуулсан.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй ба уг төв нь “Job Fair” нээлттэй өдөрлөгүүдийг зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчдыг сургуулиас гарах, жилийн чөлөө авах, эсвэл шилжин суралцах байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор санал, өргөдлийн системдээ тулгуурлан ирээдүйн шилжих хөдөлгөөний асуудлыг төлөвлөдөг байх

#### **Зөвлөмж:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгааны үр дүнд бодлогын хувьд үйл ажиллагаагаар дэмжин гүйцэтгэж, ахиц дэвшлийг үнэлдэг байх

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Төгсөлтийн баримт бичгийн загвар

- Төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилтийн байдал

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөлтийн баримт бичгийн загвар болон төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилт нь Дээд боловсролын тухай хууль, БСШУЯ-аас баталсан нийтлэг загвар стандартад бүрэн нийцсэн байна.

## **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## **Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Маркетингийн туршлагатай багш нартай.
- Багшлах бүрэлдэхүүний 50-аас дээш хувь нь докторын зэрэгтэй.
- Багшийн Хөгжлийн Төвийг 2020 онд үүсгэн байгуулсан.
- Багшийн хөгжлийн нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэй.
- Багшийн урамшууллын дүрэм журам тодорхой, ил тод.
- Багш сонгон шалгаруулах үйл явц тодорхой, ил тод.

### **Анхаарах асуудал:**

- Багшийн сургалтын үйл ажиллагааны ачаалал их. Дунджаар 30-50 хувийн илүү цагийн ачаалалтай. Өнгөрсөн жилд багшийн цагийн ачаалал А цаг 17 БЦ, Б цаг 8 БЦ боловч нэг багшид ноогдох А цагийн нормоос давсан илүү цаг 12 багц цаг байсан.
- Багшийн сурган заах арга зүйн чадварыг хөгжүүлэх сургалтын тоо цөөн.
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоо сул.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн багшийн тоог нэмэгдүүлэх

- Багшийн сурган заах арга зүйн чадварыг хөгжүүлэх сургалтын тоог нэмэгдүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан мөнгөн болон мөнгөн бус урамшууллын тогтолцоог сайжруулах

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
- Төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа хийгддэг, судалгааны дагуу Багшийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг.
- Багш нарыг урт болон дунд хугацаанд гадаадын их дээд сургуулиудад мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамруулан чадавхжуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд үнэлгээ хийж, эргэх холбоог бий болгоход анхаарах

#### **Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийн төлөвлөгөөний KPI буюу гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг тодорхойлон гүйцэтгэлд үнэлгээ хийдэг байх, үр дүнд үндэслэсэн эргэх холбоог бий болгодог байх

## **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентын тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Зарцуулсан төсөв, тайлан

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг сургуулийн вэб дээр байршуулан олон нийтэд сурталчилдаг.
- Гадаадын сэтгүүлд хэвлүүлсэн багш нарын бүтээлийн тоо нэмэгдсэн.
- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн багш нарыг урамшуулдаг тогтолцоотой.

**Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын төсвийн хэмжээг нэмэгдүүлэх
- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн багш нарыг урамшууллыг нэмэгдүүлэх

**Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын төсвийн хэмжээг нэмэгдүүлэх

**6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн өөрийн үнэлгээ хийх нэгдсэн арга зүйтэй
- Багшийн хөгжил чадамжийг Мэдлэг оюуны, Хувь хүний, Судалгааны, Сургахуйн чадамж гэсэн чиглэлүүдээр үнэлдэг.
- Багшийн үнэлгээнд оюутны сэтгэл ханамж, удирдлага, тэнхимийн хамт олны үнэлгээг оруулдаг.

**Анхаарах асуудал:**

- Багшийн нийгэмд үзүүлж буй үйлчилгээ, түүний үр дүнг ажлын үнэлгээнд оруулж тооцдоггүй.
- Сургуулийн захиргааны шинжтэй ажилд (ажлын хэсэгт ажиллах зэрэг) оролцож буй байдлыг ажлын ачаалалд оруулж тооцдоггүй.

**Зөвлөмж:**

- Их сургуулийн багшийн нийгэмд үзүүлж буй үйлчилгээ, түүний үр дүнг ажлын үнэлгээнд оруулж тооцдог тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах
- Сургуулийн захиргааны шинжтэй ажилд (ажлын хэсэгт ажиллах зэрэг) оролцож буй байдлыг ажлын ачаалалд тооцдог болох

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан****Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

### **Илрэл нотолгоо:**

- “Маркетинг” хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт нь ХААИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч мэргэжлийн тэнхимийн хөтөлбөрийн хороо гэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлдэг байна.
- ХААИС-ийн захирлын 2015 оны 11 сарын 24-ий А377 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн хорооны журам, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журмыг мөрдөн хөтөлбөрийг сайжруулан ажилладаг.
- ХААИС-ийн захирлын 2016 оны 3 сарын 9-ний өдрийн 45 тоот тушаалаар “Маркетинг” мэргэжлийн хөтөлбөрийн хороог байгуулан ажиллаж эхэлсэн ба бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны ахлагчаар ЭЗБС-ийн захирал, хөтөлбөрийн дэд хорооны нарийн бичгийн даргаар сургалтын арга зүйч, мэргэжлийн хөтөлбөрийн хорооны ахлагчаар тэнхимийн эрхлэгч, гишүүдээр багш, оюутан, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэй ажилладаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн чанарын тогтолцооны үйл явц нь маркетинг мэргэжлийн зах зээл дэх эрэлт, хэрэгцээ, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааны төлөвлөлт, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааны хэрэгжүүлэлт, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааны явцын хяналт, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааны үр дүн сэтгэл ханамж гэсэн 5 үе шатаар хэрэгжүүлдэг байна. Энэ нь хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлдэг ба чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмыг оновчтой бүрдүүлсэн болохыг илэрхийлж байна гэж үзлээ.
- “Маркетинг” хөтөлбөрийн сургалтыг богиносгосон улирлаар явуулж, хичээл сургалтын үр дүнг улирал тутамд дүгнэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажиллагаа тогтмолжсон байна.
- Хөтөлбөрийн үндсэн оролцогч талуудаас жил бүр судалгаа авч оролцогч талуудын санал, зөвлөмжийг хөтөлбөрийг сайжруулалтад тусгадаг үйл ажиллагаа тогтмолжсон байна.
- “Маркетинг” хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын цогц тогтолцоог “Маркетинг хөтөлбөр, мэргэжлийн тэнхимийн хөтөлбөрийн хороо, ЭЗБС-ийн хөтөлбөрийн дэд хороо, ХААИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо” гэсэн 4 үе шат бүхий нарийн уялдаа бүхий бүтэц, зохион байгуулалттайгаар бүрдүүлэн ажиллаж байна.

#### **Зөвлөмж:**

- Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж сайжруулахдаа оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад хэр нийцэж байгааг судалж үнэлэлт дүгнэлт өгөх.

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- 2019 онд ХААИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын албанаас төгсөгчдийн мэдээллийн санг бүрдүүлэх мөшгөх тогтолцоо бүхий төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьер өсөлт, төгсөлтийн дараа ажлын байраар хангагдах хугацаа зэрэг асуулгаас бүрдсэн судалгааг багтаасан программ хангамжийг шинэчлэн боловсруулж, судалгааны өгөгдлийг ашиглаж эхэлсэн байна.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанаас үзэхэд нийт төгсөгчийн 33.5 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж, 15.4 хувь нь мэргэжлийн дагуу ахисан түвшний сургалтад хамрагдаж байна.
- “Маркетинг” хөтөлбөрөөр төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааны үр дүнгээс харахад ахисан түвшний сургалтад хамрагдаж Бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан төгсөгчид 10.8 хувь, докторын зэрэг хамгаалсан төгсөгчид 1.3 хувийг тус тус эзэлж байна.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэг уламжлал тогтсон. Оролцогч талуудын үнэлгээ жил тутам өссөн байна.
- “Маркетинг” хөтөлбөрөөр төгсөгчийн хувь хүний мэргэжлийн, оюуны болон ерөнхий ур чадваруудыг эзэмшүүлэх чиглэлээр оролцогч талуудын санал, хүсэлтийг хөтөлбөрийг шинэчлэхэд түлхүү анхаарч ажиллаж байна.
- Оюутны мэдлэгийг үнэлэх системийг хичээл заасан багшийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээ гэсэн 2 үнэлгээгээр бүрдүүлдэг болсон нь хөтөлбөрийн үр дүнг сайжруулах, төгсөгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ихээхэн үр дүнтэй байна.

### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн дагуу ХАА-н салбарт, хөдөө орон нутагт ажил эрхлэх байдал хэр байгааг тодруулан судлах.
- Төгсөгчдийн хэдэн хувь ХАА-н маркетинг, ХАА-н бизнесийн удирдлагын чиглэлээр ахисан түвшний сургалтанд хамрагдаж магистр, докторын зэрэг хамгаалж байгааг тодорхойлон судлах, энэ чиглэлийн сургалтыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

### **Зөвлөмж:**

- ХАА-н маркетинг, ХАА-н бизнесийн удирдлагын бакалаврын төгсөгчдийн дараах мэргэжил дээшлүүлэх дунд шатны мэргэшүүлэх богино хугацаат сургалтуудыг зохион байгуулахад анхаарах
- “Маркетинг” хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын талаар авсан асуулга, сэтгэл ханамжийн судалгааг ХАА-н салбар, нэгжүүд, хөдөө орон нутгийн ажил олгогч, тэнд ажиллаж буй төгсөгчдөөс авахад анхаарах. Ингэснээр ХАА-н чиглэлийн маркетингийн мэргэжилтэн бэлтгэдэг гэсэн хөтөлбөрийн онцлог илүү сайжран хөгжих боломж бүрдэнэ.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- “Маркетинг” хөтөлбөр нь 2009 онд дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр анх удаа магадлан итгэмлэгдсэн. Гэрчилгээ №24
- 2015 онд Олон улсын бизнесийн сургууль болон хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг ACBSP байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн. /ОУМИ-ийн гэрчилгээтэй/

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлийн гэрчилгээ нь уг хөтөлбөрийн чанарын түвшинг илтгэх нэг гол үзүүлэлт болж байгаа юм.
- Үндэсний хэмжээнд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь Монголын маркетингийн холбооны гишүүн, удирдах зөвлөл, тус холбооны дэргэдэх маркетингийн мэргэжлийн багш нарын зөвлөлд гишүүнээр ажиллаж, бусад их дээд сургуулийн мэргэжлийн багш нартай хамтран мэргэжлийн ном орчуулах, хамтран зохиогчоор ажиллаж, нийтийн хүртээл болгох ажлыг тогтмол гүйцэтгэж иржээ.

#### Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах байдал жил бүр буурч байгаад анхаарах.
- Төгсөгчдийг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарах.

#### Зөвлөмж:

- Төгсөгчдийг ХАА-н чиглэлийн бизнесийг хөгжүүлэх цахим худалдаа маркетингаар илүү нарийн мэргэшүүлэх богино хугацааны ахисан, дунд шатны маркетингийн сургалтуудыг ХААИС-ийн маркетингийн тэнхим дээрээ бий болгон хөгжүүлэхэд анхаарах.

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ баталгаажуулалт	2			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Эдийн Засаг Бизнесийн Сургуулийн “Маркетинг” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий



шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

### НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	ХААИС-ЭЗБС
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Маркетинг
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D041401
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- ХААИС-ийн маркетингийн хөтөлбөрийн онцлог, давуу талыг дижитал ертөнц, даяарчлагдсан нийгэмд шаардлагатай хэрэгцээтэй уялдуулан ХАА-н маркетингийн мэдлэг чадварыг түлхүү олгоход анхаарч Монголын хөдөө аж ахуйн салбарын зах зээл дэх маркетингийн мэргэжлийн эрэлт, хэрэгцээний чиг хандлагыг судлан түүнд нийцүүлэн хөтөлбөрийн шинэчлэл хийснээр хөтөлбөрийн давуу тал, ялгарлыг бий болгох.</li> <li>- “Маркетинг” хөтөлбөр дэх маркетингийн хичээлүүд, хичээлийн агуулгад ХАА-н салбарын маркетинг, цахим худалдаа, цахим маркетингийн онол, арга зүй, дадлагыг бүрдүүлэхэд анхаарч оюутны үйлдвэрлэлийн дадлагыг ХАА-н салбар, нэгжид, орон нутагт хийлгэх, дадлагажуулахад анхаарах</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутны цогц чадамжийг тодорхойлон, сэтгэн бодох, шийдвэр гаргах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтын арга зүйг нэвтрүүлэх.</li> <li>- Маркетингийн орчин үеийн чиг хандлага болсон дижитал маркетинг, социал маркетинг, мэргэжлийн программ хангамж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаарх мэдлэг ур чадварыг хөгжүүлэхэд анхаарах</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын цахим орчны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд оюутнуудад интернэтгүй орчинд нэвтрэх боломжоор хангах</li> <li>- Орчин үеийн шинэлэг программ хангамжуудыг маркетингийн сургалтад нэвтрүүлэх</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах, мэдлэг, ур чадварыг ахисан түвшинд нэмэгдүүлэхэд анхаарах</li> <li>- Орлогын бусад эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарах (Судалгаа шинжилгээ, төсөлт хөтөлбөр хэрэгжүүлэх, захиалгат төсөл хэрэгжүүлэх, бизнес зөвлөгөө өгөх, гарааны бизнес, бизнес инкубатор ажиллуулах гэх мэт)</li> <li>- Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй олон төрлийн хөтөлбөрөөр дамжуулан суралцагчдыг солилцооны хөтөлбөрт хамруулах байдлыг идэвхжүүлэх</li> </ul>

Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн зорилгын онцлогтой уялдуулан элсэгчдэд тавигдах шаардлагаа шинэчлэн сайжруулах</li> <li>- Суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих болон сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлэх</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн багшийн тоог нэмэгдүүлэх</li> <li>- Их сургуулийн багшийн нийгэмд үзүүлж буй үйлчилгээ, түүний үр дүнг ажлын үнэлгээнд оруулж тооцдог тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж сайжруулахдаа оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад хэр нийцэж байгааг судалж үнэлэлт дүгнэлт өгөх.</li> <li>- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын талаар авсан асуулга, сэтгэл ханамжийн судалгааг ХАА-н салбар, нэгжүүд, хөдөө орон нутгийн ажил олгогч, тэнд ажиллаж буй төгсөгчдөөс авдаг болох.</li> <li>- Төгсөгчдийг ХАА-н чиглэлийн бизнесийг хөгжүүлэх цахим худалдаа маркетингаар илүү нарийн мэргэшүүлэх богино хугацааны ахисан, дунд шатны маркетингийн сургалтуудыг ХААИС-ийн маркетингийн тэнхим дээрээ бий болгон хөгжүүлэх</li> </ul>
<b>ШААРДЛАГА</b>	
<b>Хэсэгчлэн хангасан юм уу хангаагүй гэсэн дүгнэлт өгсөн шалгуур, дэд шаардлага бүрд заавал шаардлага бичнэ.</b>	
3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрөөр суралцагчдын ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сүүлийн үеийн бүтээлүүдээр ном, сурах бичгийн баяжилтыг хийх</li> </ul>

#### IV.Ярилцлагад оролцогчдыннэрс

##### I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Тэнхим	Албан тушаал	Зэрэг дэв	Ажилласан жил	Хичээлийн нэр
<b>Боловсролын суурь</b>						
1	Ж.Анхбаяр	МФМТ	Багш	Магистр	13	Математик I
2	Х.Сүнжидмаа	Хүмүүнлэгийн ухааны	Багш	Магистр	15	Англи хэл I
3	М.Мөнгөнзул	Хүмүүнлэгийн ухааны	Багш	Магистр	15	Англи хэл II
4	Ч.Хулан	Хүмүүнлэгийн ухааны	Ахлах багш	Доктор	16	Монгол хэл бичиг найруулга зүй
5	Б.Батзориг	ББХ	Тэнхимийн эрхлэгч	Магистр	14	Биеийн тамир, эрүүл ахуй
6	Т.Азбаяр	ХХААХЭЗ	Багш	Магистр	22	Эдийн засгийн онол
7	Д.Эрдэнэбаатар	ББХ	Ахлах багш	Доктор	18	Гамшгаас хамгаалах менежмент

<b>Мэргэжлийн суурь</b>						
1	Ш.Дэнсмаа	ХХААХЭЗ	Ахлах багш	Магистр	32	Микро эдийн засаг
2	Ж.Баттулга	ХХААХЭЗ	Ахлах багш	Доктор	17	Макро эдийн засаг
3	Д.Отгондаваа	Бизнесийн менежмент	Багш	Магистр	15	Менежментийн үндэс
4	Я.Нансалмаа	НББШ	Багш	Магистр	21	Нягтлан бодох бүртгэлийн үндэс
5	Б.Ариунболд	Санхүү	Багш	Магистр	8	Санхүүгийн үндэс
<b>Мэргэшүүлэх</b>						
1	Д.Туул	Маркетинг	Дадлагажигч багш	Магистр	3	Хөдөө аж ахуйн маркетинг
2	Л.Тогтохбуян	Маркетинг	Ахлах багш	Доктор	19	Маркетингийн судалгаа, шинжилгээ
3	Д.Алтантуяа	Маркетинг	Ахлах багш	Магистр	16	Зах зээлийн судалгаа
4	Л.Отгонжаргал	Маркетинг	Тэнхимийн эрхлэгч	Доктор	26	Байгууллагын маркетинг
5	З.Ундрах	Маркетинг	Ахлах багш	Магистр	21	Дижитал маркетинг
<b>Сонгон судлах</b>						
1	Д.Кадирбек	Менежмент	Ахлах багш	Магистр	21	Үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежмент
2	С.Баасансүрэн	Менежмент	Ахлах багш	Магистр	24	Төслийн менежмент
3	Г.Золзаяа	Статистик эконометрик	Ахлах багш	Доктор	13	Эдийн засгийн прогнозчлол
4	Т.Эрдэнэчулуун	ХХАХЭЗ	Ахлах багш	Доктор	23	Байгалийн нөөцийн эдийн засаг
5	П.Буяннэмэх	Санхүү	Ахлах багш	Доктор	10	Санхүүгийн менежмент

## II. Оюутнынэрс

№	Оюутны нэрс	Оюутны код	Анги, хэсэг	Сонгосон байдал
1	Ц.Ануужинтөгс	5418028	Маркетинг-IV	Голч дүн 3.4
2	О.Халиун	5418026	Маркетинг-IV	
3	У.Энхжин	5418034	Маркетинг-IV	Голч дүн 3.2

4	П.Баасанням	5418011	Маркетинг-IV	
5	М.Чингүн	5418039	Маркетинг-IV	
6	Ж.Жавзанпагма	5418003	Маркетинг-IV	Голч дүн 3.5
7	Б.Болор	5418015	Маркетинг-IV	
8	У.Оюун	5418044	Маркетинг-IV	
9	С.Ариунжаргал	5418007	Маркетинг-IV	
10	Г.Сийлэгмаа	5418025	Маркетинг-IV	
11	Г.Чулуунцэнд	5419002	Маркетинг-III	- Оюутны байранд - Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагын сайн дурын ажилтан
12	Ө.Энхтайван	5419013	Маркетинг-III	Оюутны байранд
13	М.Мөнхдорж	5419012	Маркетинг-III	- Монголын скаутын холбооны товчооны гишүүн - Хүүхэд залуучуудын зөвлөлийн дарга - НҮБ хүүхдийн сан уур амьсгалын өөрчлөлт агаарын бохирдлын төслийн зохицуулагч
14	А.Даваахүү	5419020	Маркетинг-III	
15	Г.Жавзансүрэн	5418008	Маркетинг-III	
16	А.Баяржаргал	5419007	Маркетинг-III	
17	Ч.Мягмардулам	5421005	Маркетинг-II	Оюутны байранд
18	С.Энхсүх	5421008	Маркетинг-II	Оюутны байранд
19	Ч.Энх-Амар	5420026	Маркетинг-I	
20	Ч.Азжаргал	5419016	Маркетинг-I	
21	М.Цэвэлсүрэн	5818001	АЖМ-IV	
22	Э.Рэнцэнхорол	5818003	АЖМ-IV	
23	А.Номин-Эрдэнэ	5818004	АЖМ-IV	

### III. Ажиллогчдын нэрс

✓ Ажил олгогчдын төлөөллийг сонгох -10-15 хүн /төрийн болон төрийн бус байгууллага/

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал	Ажилтны нэр
---	-----------	-------------	--------------	-------------

1	О.Галбадрах	АПУ ХК, трэйд маркетингийн алба	Албаны дарга	Намуундарь, Билембек
2	Б.Одбаясал	Төрийн банк, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, судалгааны хэлтэс	Хэлтсийн захирал	Дагийжанчив, Азжаргал
3	С.Долгорсүрэн	ММСG ХХК, мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын газар	Газрын захирал	Дашням, Бямбажаргал, Наранзул
4	Б.Батзориг	BZP digital & inbound marketing agency	Үүсгэн байгуулагч, Захирал	М.Амаржаргал Б.Хулан
5	Б.Шийтэрчулуун	Олон нуур агро ХХК	Гүйцэтгэх захирал	Н.Намжилмаа
6	Г.Дорждагва	АВО Maroon Tussen Group ХХК	Гүйцэтгэх захирал	Д.Сайханбаяр
7	Т.Алтанхундага	Скай хайпермаркет, Маркетинг төлөвлөлтийн хэлтэс	Хэлтсийн дарга	Б.Уянга А.Жавзандулам
8	Ө.Ганбаатар	МХААХҮ-ний холбоо	Гүйцэтгэх захирал	Хажидсүрэн, Батчимэг
9	Б.Уранжаргал	MSM групп, Маркетингийн алба	Ахлах менежер	Бадамхатан
10	Б.Бүрэнзаяа	ХААН банк, картын үйл ажиллагааны газар	Ахлах мэргэжилтэн	Б.Төрболд Ц.Сэлэнгэ
11	Ч.Батбаяр	Монгол экологийн бордоо ХХК	Захирал	М.Солонго Б.Наранзул
12	Х.Мөнхтуяа	ТЕСО групп, Милко ХХК, Маркетингийн алба	Албаны дарга	Амарбаясгалан, Рэнцэндорж

#### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Э.Мөнхтуул	2015	“Мика Монгол” ТББ	Маркетинг, үйл ажиллагаа хариуцсан менежер
2	М.Батжаргал	2015	Хас банк	Зээлийн мэргэжилтэн
3	Э.Лхагва	2015	Зебра интернэйшнл ХХК	Суваг хариуцсан менежер
4	М.Амаржаргал	2016	BZP digital & inbound marketing agency	Маркетингийн менежер
5	Л.Баянхангай	2016	Хавдар судлалын үндэсний төв	Захирлын туслах
6	А.Баярмаа	2017	Талх чихэр ХК, борлуулалтын алба	Ахлах менежер
7	Ц.Номин-Эрдэнэ	2017	Нано интернэйшнл	Брэнд,

			ХХК	маркетингийн ахлах мэргэжилтэн
8	Т.Долгорсүрэн	2018	Сүү ХК, Маркетингийн алба	Маркетингийн менежер
9	М.Мөнхболд	2018	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	Маркетинг, мэдээллийн технологийн ажилтан
10	М.Гантулга	2018	Мари Стопс олон улсын байгууллага	Маркетингийн менежер
11	Б.Энхбадрал	2020	Эхлэл брэнд ХХК	Маркетингийн менежер
12	Г.Бямбажаргал	2020	ММСГ ХХК	Судалгааны менежер
13	Б.Сундуй (Аялал жуулчлалын маркетингийн төгсөгч)	2021	Баттрейд ХХК	Салбарын маркетингийн менежер
14	Б.Мягмардаш (Аялал жуулчлалын маркетингийн төгсөгч)	2021	Rentpay solution ХХК	Зөвлөх менежер
15	Д.Амгаланбаатар *Аялал жуулчлалын маркетингийн төгсөгч)	2021	Сити альянс ХХК	Төслийн менежер

**V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**ХОДОО АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ  
ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН  
СУРГУУЛЬ**

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
11 дугаар хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 252, 253  
И-мэйл: info\_sab@mu.edu.mn  
Вэб сайт: www.mu.edu.mn

2021-11-10 № 01/269  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

**Шинжээчдийн дүгнэлтэд хариу  
хүргүүлэх тухай**

Маркетингийн тэсвэрийн "Маркетинг" /D041401/ бакалаврын сургалтын хотолбор нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж буй эсэхэд хондлогийн үнэлгээ хийлгэхээр хотолборийн өөрийн үнэлгээний тайланг хүргүүлсэн билээ. Үүний дагуу хондлогийн шинжээчдийн баг 2021 оны 10 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд өөрийн үнэлгээний багийн гишүүдтэй хамтран ажлаж, шалгуур тус бүрийн нотлох баримттай танилцан ажигласан бөгөөд 2021 оны 11 дугаар сарын 10-нд ирүүлсэн шинжээчийн тайлангаар уншиж танилцлаа.

"Маркетинг" бакалаврын сургалтын хотолборийн өөрийн үнэлгээний тайланд тусгасан зөвлөмж, дүгнэлтийг хүлээн авч, цаашид хэрэгжүүлэн ажиглах болно.

Зөвлөмж өгч хамтран ажигласан шинжээчдийн багийн ахлагч доктор, профессор Г.Болдбаатар, багийн гишүүд болох доктор, профессор Б.Даваасүрэн, доктор, дэд профессор О.Бурмаа болон БМУЗ-ийн ажлын албаны магадлан итгэмжлэл харууцсан мэргэжилтэн доктор Г.Даваажаргал нарт талархалаа илэрхийлэе.

ЗАХИРАЛ  Б.БААЛСАНСҮХ

**ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж/Recommendations/**

**ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)  
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн  
дүгнэлт]

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

**Зөвлөмж/Recommendations/**